

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“АЛТАЙ-УЛИАСТАЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ” ТӨХК-ИЙН 2018 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

АУДИТЫН КОД: САГ-2019/107/СТА-ТӨХК

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан	4
2.1.	Оршил	4
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.8.1	Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл	7
2.8.2	Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал	8
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.10.	Зорилтот түвшний хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	9
2.11.	Шилэн дансны мэдээлэл	10
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	10
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
3	Менежментийн захидал	11
3.1	Авлагатай холбоотой асуудал	11
3.1.1	Илрүүлэлт:	11
3.1.2	Эрсдэл:	11
3.1.3	Өгсөн зөвлөмж:	11
3.1.4	Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:	12
3.2	Хөрөнгөтэй холбоотой асуудал	12
3.2.1	Илрүүлэлт:	12
3.2.2	Эрсдэл:	12
3.2.3	Өгсөн зөвлөмж:	12
3.2.4	Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:	12
3.3	Татвар, шимтгэлтэй холбоотой асуудал	12
3.3.1	Илрүүлэлт:	12
3.3.2	Эрсдэл:	13
3.3.3	Өгсөн зөвлөмж:	13

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:	13
4 Аудит хийсэн санхүүгийн тайлан	14
4.4.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан	14
4.2 Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан	16
4.3 Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан	17
4.4 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан	18
5 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
УЦС	Усан цахилгаан станц
УТЗ	Урьдчилж төлсөн зардал
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ЦДҮС	Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

“АЛТАЙ-УЛИАСТАЙН ЭРЧИМ
ХҮЧНИЙ СИСТЕМ” ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ А.ПҮРЭВСҮРЭН
ТАНАА

2019. 03 15 № 06/483
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Алтай-Улиастайн эрчим хүчний систем” ТӨХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

“Алтай-Улиастайн эрчим хүчний систем” ТӨХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Алтай-Улиастайн эрчим хүчний систем” ТӨХК-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

071234

Үүрэг, хариуцлага

“Алтай-Улиастайн эрчим хүчний систем” ТӨХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

“Алтай-Улиастайн эрчим хүчний систем” ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан, дүгнэлтийг “Алтай-Улиастайн эрчим хүчний систем” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал А.Пүрэвсүрэн танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Алтай-Улиастайн эрчим хүчний систем” ТӨХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

“Алтай-Улиастайн эрчим хүчний систем” ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт гаргах нь энэхүү аудитын зорилт байв.

“Алтай-Улиастайн эрчим хүчний систем” ТӨХК-ийн удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 2 дугаар сарын 23-наас 3 дугаар сарын 15-ны хооронд хийхээр төлөвлөн, ҮАГ-ын захиалгаар “Акпар-Аудит” ХХК-ийн захирал Х.Баянбай, аудитор Ж.Амаржаргал, М.Хосбаяр, аудиторын туслах Э.Нармандах нар хариуцаж хэрэгжүүлэв.

“Алтай-Улиастайн эрчим хүчний систем” ТӨХК нь 2018 оны жилийн эцсийн нэгдсэн санхүүгийн тайланг 2019 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн 146 дугаартай албан бичгээр “Акпар-Аудит” ХХК-д ирүүлсэн боловч Төсвийн тухай хуульд заасан цаглабарт хугацааг 10 хоногоор хоцроосон.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, НББОУС, СТОУС, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

“Алтай-Улиастайн эрчим хүчний систем” ТӨХК-ийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Говь-Алтай, Завхан аймгийн хэрэглэгчдийн цахилгаан эрчим хүчний өсөн нэмэгдэж буй хэрэгцээг хосолсон эх үүсвэрүүдээр тасралтгүй, найдвартай хангах.

Дээрх зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна. Үүнд:

- Хоёр аймгийн хэмжээнд хүрэлцэхүйц цахилгааны найдвартай эх үүсвэртэй болох,
- Системийн энерги алдагдлыг үе шаттайгаар бууруулах,
- Техник зохион байгуулалтын ажлын хэлтэс, ТЭЗҮ-ийн биелэлтийг хангаж, үр ашигтай ажиллах,
- Хүний нөөцийн чадавхыг сайжруулж, мэргэжилтнүүдийн үр чадварыг дээшлүүлэх.

Чиг үүрэг:

- ЦДҮС-ээс авах цахилгаан эрчим хүчний хүчин чадлыг нэмэгдүүлэх техник, технологийн шинэчлэлт хийх,
- Сэргээгдэх болон дулааны цахилгаан станц барьж байгуулах,
- Энергийн балансыг сар, жилээр гарган дүн шинжилгээ хийж, алдагдлын мөрөөр төлөвлөгөөт ажлуудыг зохион байгуулах,
- Сургалт, хөгжлийн төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх.

“Алтай-Улиастайн эрчим хүчний систем” ТӨХК-ийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

“Алтай-Улиастайн эрчим хүчний систем” ТӨХК-ийн удирдлага Сангийн сайдын баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль,
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль,
- Шилэн дансны тухай хууль,
- Эрчим хүчний тухай хууль,
- Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль,
- Нийгмийн даатгалын болон татварын багц хуулиуд.

Тайлант хугацаанд дээрх хууль болон бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

“Алтай-Улиастайн эрчим хүчний систем” ТӨХК-ийн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

“Алтай-Улиастайн эрчим хүчний систем” ТӨХК-ийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагааг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

“Алтай-Улиастайн эрчим хүчний систем” ТӨХК нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Ординат” ХХК-ийн “Винница” програм хангамж ашигладаг байна.

“Алтай-Улиастайн эрчим хүчний систем” ТӨХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт “үр нөлөөгүй” гэж үзлээ.

Тус компанийн дотоод аудитын алба нь 4 хүний орон тоотой ажиллаж байгаа бөгөөд 2018 онд санхүүгийн тайлангийн болон гүйцэтгэлийн аудитаар илэрсэн зөрчилтэй холбоотой зөвлөмжийн биелэлтийг гаргаж, захирлын зөвлөлд танилцуулсан байна.

Санхүү бүртгэл, хөрөнгийн ашиглалт, зарцуулалт, хамгаалалтад тавих хяналт сул, аудиторуд нь шинээр орсон, ажлын туршлагагүй, зарим үед орон тоо дутуу ажилладаг зэрэгт анхаарал тавих шаардлагатай байна.

(САГ-2019/107/СТА-ТӨХК)

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 39 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 39 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогын дүнг сонгов.

Энэ нь нийт орлогын дүн харьцангуй бага байсантай холбоотой юм.

“Алтай-Улиастайн эрчим хүчний систем” ТӨХК-ийн 2018 оны нийт орлогын дүн 11,650.9 сая төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 116.5 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь тэвчиж болох хамгийн бага дүнг сонгосонтой холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 11 чиглэлээр аудитын 39 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 7 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 32 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэсэн.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

2.8.1 Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

2.8.2 Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал

Залруулаагүй алдаа, зөрчилтэй
асуудлыг ангилсан байдал

(Сая төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	3	104.1	Өгсөн зөвлөмжийн талаар энэхүү тайлангийн 3 дугаар хэсэгт дэлгэрэнгүй бичсэн
	Дүн	3	104.1	

2.8.2.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудал байгаагүй.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Тус аймгийн татварын хэлтсийн улсын байцаагчдын 2016 оны 10 дугаар сарын 3-ны өдрийн 050021475 дугаартай актаар тус компанийн харьяа “Тайшир-Гуулин УЦС” ХХК-д үл хөдлөх хөрөнгийн нөхөн татварт 423.1 сая төгрөгийн нөхөн татвар ногдуулсан байна.

Дээрх 423.1 сая төгрөгийн үл хөдлөх хөрөнгийн нөхөн татвар нь зөвхөн 2014-2015 оны татвар байсан ба 2016-2018 онуудын татварт дахин 678.0 сая төгрөг ногдож, татварын өр болон алдагдлын хэмжээг дахин нэмэгдүүлэх магадлалтай байна.

“Алтай-Улиастайн эрчим хүчний систем” ТӨХК нь Бигэр сумын Өөшийн тариалангийн талбайд цахилгаан дамжуулах агаарын шугам татах дэд станцыг 19.0 сая төгрөгөөр барьсан байна.

Дэд станцын төлбөрийг Бигэр сумын орон нутгийн хөгжлийн сангаас 2018 оны 6 дугаар сарын 30-ны дотор төлөхөөр тохиролцсон боловч 2018 онд төсөвт тусгагдаагүй тул 2019 онд Бигэр сумын орон нутгийн хөгжлийн сангаас төлөхөөр сумын ИТХ-ын тогтоол гарсан байна.

“Алтай-Улиастайн эрчим хүчний систем” ТӨХК нь аваарын нөөцийн тоног төхөөрөмж нийлүүлэх АУ/17/23 дугаартай гэрээг 2017 онд "Орд харш" ХХК-тай байгуулжээ. Гэрээгээр нийлүүлэх тоног төхөөрөмжөөс 6 нэр төрлийн тоног төхөөрөмжийг дутуу нийлүүлжээ.

Дутуу нийлүүлсэн тоног төхөөрөмжийг 2018 оны 6 дугаар сарын 15-ны дотор нийлүүлэх үүрэг авсан боловч 2019 онд 1/7 дугаартай албан бичиг ирүүлж, гэрээний хугацааг 2019 оны 3 дугаар сарын 25-ны хүртэл сунгаж өгнө үү гэсэн хүсэлт тавьсан байна.

Эрчим хүчний зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 477 тоот тогтоол, “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 26-н өдрийн 34 дүгээр тогтоолоор 1,619.8 сая төгрөгийн үнэтэй тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг тус компанид шилжүүлсэн байна.

Тоног төхөөрөмжийг 2018 онд орлого авсан боловч одоо хүртэл “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн агуулахаас татаж аваагүй байна.

Тус компани нь 43.5 тэрбум төгрөгийн урт хугацаатай зээлийн өртэй байна. Энэхүү зээл нь тус компанийн нийт эргэлтийн хөрөнгөнөөс 9.5 дахин их байна.

Байгууллагын төлбөрийн чадвар, төлөх хөрөнгийн боломжоос хэд дахин давсан, төлбөр хийх хөрөнгийн ямар ч эх үүсвэргүй эдгээр зээлийг цаашид хэрхэх талаар Засгийн газарт танилцуулж, шийдвэрлүүлэх асуудлыг улсын хэмжээнд зохион байгуулах шаардлагатай байна.

Үл хөдлөх хөрөнгө буюу барилга, газрын дахин үнэлгээг компанийн гүйцэтгэх захирлын 2018 оны А/37 дугаартай тушаалаар байгуулагдсан ажлын комисс, харин цахилгаан үйлдвэрлэх, дамжуулах, хуваарилах, тоног төхөөрөмж, шугам сүлжээний дахин үнэлгээг “Хөрөнгийн үнэлгээний төв” ХХК-ийн үнэлгээчин, 071200023 дугаартай Хөрөнгийн үнэлгээ хийх тусгай зөвшөөрөлтэй Ж.Уртнасангаар хийлгэсэн байна.

Говь-Алтай аймаг дахь үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээний нягтлан шалгах ажлыг 091100183 дугаартай Хөрөнгийн үнэлгээ хийх тусгай зөвшөөрөлтэй Д.Энхтайванаар, Завхан аймаг дахь үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээний нягтлан шалгах ажлыг 016012096 дугаартай Хөрөнгийн үнэлгээ хийх тусгай зөвшөөрөлтэй Н.Эрдэнэцэцэгээр тус тус хийлгэсэн байна.

Үнэлгээнд барилга, байгууламжийн хийц бүтэц болон холбогдох итгэлцүүрүүд, нэгжийн жишиг үнэлгээ, элэгдлийн хувь, ашиглалтын норматив хугацаа зэргийг зөв тодорхойлж, аргачлалын дагуу зөв тооцоолсон байна.

Харин дахин үнэлгээгээр тус компанийн барилга, байгууламжийн үлдэгдэл өртөг 68.7 хувиар нэмэгдсэн байна. Энэ нь элэгдлийн болон үл хөдлөх хөрөнгийн татварын зардлыг дахин нэмэгдүүлэх ба хэрэглэгчдээс авах цахилгааны тарифт өөрчлөлт ороогүй нөхцөлд алдагдлын хэмжээг улам нэмэгдүүлэх сөрөг хандлагатай байна.

2018 оны 10 дугаар сард Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газраас тус компанийн 2016-2017 оны үйл ажиллагааны хэрэгжилт, үд дүнд гүйцэтгэлийн аудит хийсэн байна.

Аудитын шалгалтаар 35.7 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоосныг бүрэн төлж, барагдуулсан байна.

Шинэчлэгдсэн Нэмэгдсэн өртгийн албан татварын хуулиар төсвөөс олгосон санхүүжилт, татаасанд нэмэгдсэн өртгийн албан татвар ногдуулах болсонтой холбоотой тус компанийн салбар, охин компаниудын хэмжээнд татварын тайлан дахь татварын өрийн үлдэгдэл санхүүгийн тайлан дахь үлдэгдлээс 366.0 сая төгрөгөөр зөрсөн байна. Энэ зөрүүг арилгах талаар аймгийн Татварын хэлтэст хандаж татварын тайлангуудыг засуулахаар хүсэлт илгээсэн боловч одоо хүртэл шийдвэрлэж өгөөгүй байна.

“Тосонцэнгэл УЦС” ХХК-д 154.4 сая төгрөгийн анхны өртөгтэй 132.7 сая төгрөгийн үлдэгдэл өртөгтэй, 1961-1987 онуудад аж ахуйн аргаар баригдсан, 1993 оноос хойш ашиглагдахгүй байгаа 11 барилга, Завхан салбарт 146.1 сая үлдэгдэл өртөгтэй барилга, байгууламж, тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байна.

Барилга, байгууламжуудыг Монгол улсын Засгийн газрын 2016 оны 193 дугаар тогтоол, Сангийн сайдын 2018 оны 207 дугаар тушаалын дагуу хийгдсэн дахин үнэлгээнд оруулаагүй бөгөөд ашиглагдахгүй байгаа дээрх хөрөнгөнүүдийг актлуулах талаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт удаа дараа хандсан боловч одоо хүртэл тодорхой шийдвэр гаргаж өгөөгүй байна.

Дээрх анхаарал татахуйц асуудлуудын үр нөлөө болон зөвлөмжийн биелэлтийг дараагийн аудитор шалгах нь зүйтэй.

2.10. Зорилтод түвшингийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2017 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 667 дугаар тогтоолоор “Алтай-Улиастайн эрчим хүчний систем” ТӨХК-ийн 2018 оны “Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтод түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө”-г баталсан байна.

2018 онд 10,993.0 сая төгрөгийн орлого оруулахаар төлөвлөснөөс 11,650.9 сая төгрөгийн орлого оруулж, орлогын төлөвлөгөөг 657.9 сая төгрөг буюу 106.0 хувиар давуулан биелүүлсэн байна.

(САГ-2019/107/СТА-ТӨХК)

Нийт 14,493.0 сая төгрөгийн зардалтай ажиллахаар төлөвлөсөн ба 13,941.7 сая төгрөгийн зардалтай ажиллаж, төлөвлөгөөт зардлыг 551.3 сая төгрөг буюу 3.8 хувиар хэмнэсэн байна.

Төлөвлөгөөт алдагдлыг 3,500.0 сая төгрөгөөр төлөвлөснөөс 2,294.0 сая төгрөгийн алдагдалтай гарч төлөвлөгөөт алдагдлыг 1,206.0 сая төгрөг буюу 34.5 хувиар бууруулсан байна.

Батлагдсан төлөвлөгөөгөөр 2018 оны жилийн эцэст нийт авлагын үлдэгдлийн дээд хэмжээг 320.0 сая төгрөг, өглөгийн үлдэгдлийн дээд хэмжээг 380.0 сая төгрөг байхаар төлөвлөсөн боловч, 441.4 сая төгрөгийн авлагатай, 585.9 сая төгрөгийн өглөгтэй гарч, төлөвлөгдсөн хэмжээнээс авлагын үлдэгдлийг 121.4 сая төгрөг, өглөгийн үлдэгдлийг 205.9 сая төгрөгөөр тус тус хэтрүүлсэн байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

“Алтай-Улиастайн эрчим хүчний систем” ТӨХК-ийн шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээллийг /<https://shilendans.gov.mn/> сайд руу орж шалгаж үзэхэд төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн байршуулах ёстой мэдээлэл болох худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл, концессын мэдээлэл, худалдан авах ажиллагааны тайлан, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл, бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр, их хэмжээнд тооцогдохуйц хэлцэлд гаргасан баталгаа, батлан даалтын мэдээллийг хугацаанд нь бүрэн оруулж, холбогдох тушаал, шийдвэрүүдийг байршуулсан байна.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 6 зөвлөмж өгснөөс 5 нь биелэгдэж, дотоод аудитын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой зөвлөмжийг биелүүлэх талаар тодорхой ажлуудыг хэрэгжүүлж эхэлсэн байна. Зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 80.0 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид “Алтай-Улиастайн эрчим хүчний систем” ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайланд аудит хийхдээ АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Алтай-Улиастайн эрчим хүчний систем” ТӨХК-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон тодруулгад тусгасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидал АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтэд үндэслэсэн болно. Санхүүгийн тайлан, тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь “Алтай-Улиастайн эрчим хүчний систем” ТӨХК-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Авлагатай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Тус компанийн авлагын дэлгэрэнгүй бүртгэл, санхүүгийн тайланд олон жил дамжсан, хариуцагч нь нас барсан, хаяг нь тодорхойгүй болсон хувь хүн болон дампуурсан, татан буугдсан аж ахуйн нэгжтэй холбоотой 21.1 сая төгрөгийн авлагыг барагдуулах ажил хийгээгүй байна.

“Тосонцэнгэл УЦС” ХХК нь 7.0 сая төгрөгийн урьдчилж төлсөн зардлыг авлагаар бүртгэж, тайлагнасан байна.

3.1.2 Эрсдэл:

Олон жил дамжсан найдваргүй авлага хөрөнгө биш учраас байгууллагын нийт хөрөнгийг хий өсгөж харуулдаг ба яваандаа алдагдал болдог.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Дээрх авлагуудын найдваргүй болсон шалтгааныг авлага бүрээр судалж, хариуцах эзэнгүй болсон авлагыг ТУЗ-ийн хуралд оруулан танилцуулж, данснаас хасах. Хариуцах эзэнтэй авлагыг зохих журмын дагуу хуулийн байгууллагад шилжүүлж, төлүүлэх арга хэмжээ авах.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Авлагын дансанд бүртгэлтэй авлагуудын насжилтын судалгааг хийж барагдуулах ажлыг зохион байгуулж, эзэн холбогдогчийг тогтоох, найдваргүй авлагыг ТУЗ-ийн хуралд танилцуулж, шийдвэрлүүлэхэд анхаарч ажиллана. Авлагаар бүртгэгдсэн урьдчилж төлсөн зардлыг 2019 оны 1 дүгээр улирлын тайлангаар залруулж, холбогдох дансанд бүртгэж, зөв тайлагнах болно.

3.2 Хөрөнгөтэй холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Элэгдлийн норм, ашиглах хугацаа дууссан мөн осол, гэмтлийн улмаас цаашид ашиглах боломжгүй болсон 431.4 сая төгрөгийн анхны үнэ, 423.2 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэл, 8.2 сая төгрөгийн үлдэгдэл өртөгтэй үндсэн хөрөнгө болон тус компанийн охин компани болох “Богдын гол УЦС” ХХК-д техник, технологийн өөрчлөлтөөс болж, хоцрогдон, хэрэгцээгүй болсон 20.9 сая төгрөгийн сэлбэг хэрэгслийг актлуулах арга хэмжээ аваагүй байна.

“Тосонцэнгэл УЦС” ХХК нь 4.9 сая төгрөгийн биет бус хөрөнгийг үндсэн хөрөнгөөр бүртгэж, тайлагнасан байна.

3.2.2 Эрсдэл:

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31.4 дүгээр зүйл буюу **“ашиглах хугацаа дуусаагүй боловч осол, гэмтлийн улмаас ашиглах боломжгүй болсон эд хөрөнгийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын зөвшөөрөлтэйгөөр энэ зүйлд заасан журмын дагуу шийдвэрлэх”** гэсэн заалт болон **“эдийн засгийн ирээдүйн үр өгөөжгүй болсон”** үндсэн хөрөнгийг данснаас хасна гэсэн НББОУС 16.67 стандартыг тус тус зөрчсөн.

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлд заасны дагуу актлах хөрөнгийн талаар байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн дүгнэлт гаргуулан, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт танилцуулж актлуулах арга хэмжээ авах.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Ашиглалтын хугацаа дууссан үндсэн хөрөнгө болон техник технологийн хоцрогдолд орсон бараа материалыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт уламжилж, хууль тогтоомжийг дагуу шийдвэрлүүлэхэд анхаарч ажиллана. Үндсэн хөрөнгөөр бүртгэгдсэн биет бус хөрөнгийг 2019 оны 1-р улирлын тайлангаар залруулж, холбогдох дансанд бүртгэж, зөв тайлагнах болно.

3.3 Татвар, шимтгэлтэй холбоотой асуудал

3.3.1 Илрүүлэлт:

Зарим ажиллагсдад олгосон шагнал урамшууллыг нийгмийн даатгалын шимтгэлд хамруулаагүй байна. Шагнал урамшууллын дүн 42.1 сая төгрөг, түүнд ногдох НДШ-ийн дүн 10.5 сая төгрөг байна.

Мөн худалдаж авсан үндсэн хөрөнгийн Нэмэгдсэн өртгийн албан татварыг төсөвт төлөх татвараас хассан байна. Тухайлбал: 2016 онд 1.0 сая төгрөг, 2017 онд 3.3 сая төгрөг, 2018 онд 29.4 сая төгрөг, 3 жилийн дүнгээр 33.7 сая төгрөг байна.

3.3.2 Эрсдэл:

Нэмэгдсэн өртгийн албан татвар болон нийгмийн даатгалын шимтгэлийг холбогдох хуульд заасны дагуу зөв ногдуулж, хугацаанд төлөөгүйгээс нөхөн татвар, алданги, хүү, торгууль төлөх эрсдэлтэй.

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Монгол улсын Засгийн газрын 1994 оны 212 дугаартай тогтоолоор баталсан журмаар Нийгмийн даатгалын шимтгэл ногдуулах хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлогод ажиллагсдад олгож байгаа бүх төрлийн шагнал, байр, орон сууц, унаа, хоол, түлээ, нүүрсний хөнгөлөлтийг оруулан тооцно гэж заасан тул ажиллагсдад олгосон бүрх төрлийн шагналыг татвар болон нийгмийн даатгалын шимтгэлийн тооцоонд хамруулж байх.

2018 оны нийгмийн даатгалд хамрагдаагүй шагнал урамшууллыг нөхөн тайлагнах арга хэмжээ авах.

2016-2017 онуудын НӨАТ-ын үлдэгдлийн зөрүүг арилгах талаар аймгийн Татварын хэлтэст хандаж татварын тайлангуудыг засуулахаар хүсэлт илгээсэн байна. Өмнөх онуудын татварын үлдэгдлийг зөрүүг арилгаж, тооцоо нийлэх үед дээрх үндсэн хөрөнгийн худалдан авалттай холбоотой тооцоог мөн хамруулах.

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

2018 оны нийгмийн даатгалд хамрагдаагүй шагнал урамшууллыг нөхөн тайлагнаж ажиллана. Цаашид шагнал урамшууллыг нийгмийн даатгалд бүрэн хамруулна.

Аймгийн татварын хэлтэст 2018 оны НӨАТ-ын тайланг засварлах хүсэлт илгээж, татварын тайлангийн зөрүүг арилгаж, алдааг залруулна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 6 дугаар сарын 10-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.4.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2017 оны 12 дугаар сарын 31	2018 оны 12 дугаар сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	706,764,758.78	451,924,376.20
1.1.2	Дансны авлага	79,343,857.84	430,800,101.28
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	17,117,080.53	19,790,768.71
1.1.4	Бусад авлага	10,635,264.00	10,635,264.00
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	1,907,501,428.43	3,415,659,745.55
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	667,761,584.74	313,787,532.11
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
	Эргэлтийн хөрөнгийн дүн	3,389,123,974.32	4,642,597,787.85
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	100,494,900,060.13	111,404,762,455.61
1.2.2	Биет бус хөрөнгө	32,600,873.49	4,785,437,414.92
1.2.3	Биологийн хөрөнгө		
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	100,527,500,933.62	116,190,199,870.53
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	103,916,624,907.94	120,832,797,658.38
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	38,045,523.83	52,798,944.85
2.1.1.2	Цалингийн өглөг		
2.1.1.3	Татварын өр	151,859,154.51	506,561,846.72
2.1.1.4	НДШ–ийн өглөг	156,859.14	
2.1.1.5	Богино хугацаат зээл		
2.1.1.6	Хүүний өглөг		
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг		
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	45,345,632.00	780,140,383.71
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/		
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	45,285,415.78	46,297,205.83
	Богино хугацаат өр төлбөрийн дүн	280,692,585.26	1,385,798,381.11
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	43,474,187,048.99	43,474,187,048.99
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр		
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр		

(САГ-2019/107/СТА-ТӨХК)

“Алтай-Улиастайн эрчим хүчний систем” ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

2.1.2.5			
	Урт хугацаат өр төлбөрийн дүн	43,474,187,048.99	43,474,187,048.99
2.2	Өр төлбөрийн нийт дүн	43,754,879,634.25	44,859,985,430.10
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:-төрийн	60,388,037,164.58	60,388,037,164.58
2.3.2	- хувийн		
2.3.3	- хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	1,503,964,488.14	16,635,666,439.18
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	18,975,469,815.51	21,948,832,209.34
2.3.9	Хуримтлагдсан ашиг	-20,705,726,194.54	-22,999,723,584.82
2.3.10			
2.3.11	Эздийн өмчийн дүн	60,161,745,273.69	75,972,812,228.28
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	103,916,624,907.94	120,832,797,658.38

4.2 Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	7,101,608,938.00	7,878,424,293.54
2	Борлуулалтын өртөг	9,976,864,407.93	11,410,682,450.79
3	Нийт ашиг(алдагдал)	-2,875,255,469.93	-3,532,258,157.25
4	Түрээсийн орлого		
5	Хүүгийн орлого	22,471,677.19	32,801,889.91
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого	2,468,159,001.86	2,256,165,494.63
9	Борлуулалт, маркетингийн зардал	40,999,989.17	49,154,095.10
10	Ерөнхий ба удирдлагын зардал	2,220,663,983.42	2,283,646,848.62
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал	271,249,279.90	198,182,153.80
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		6,200,000.00
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)	679,236,814.15	1,477,340,725.54
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-2,238,301,229.22	-2,290,733,144.69
19	Орлогын татварын зардал	2,247,167.71	3,276,937.36
20	Татварын дараах ашиг (алдагдал)	-2,240,548,396.93	-2,294,010,082.05
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-2,240,548,396.93	-2,294,010,082.05
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
23.3	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн		
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

4.3 Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2016 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	60,388,037,164.58	1,503,964,488.14	17,175,469,815.51	-18,449,318,126.63	60,618,153,341.60
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				-15,859,670.88	-15,859,670.88
3	Залруулсан үлдэгдэл					
4	Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал)				-2,240,548,396.93	-2,240,548,396.93
5	Бусад дэлгэрэнгүй орлого					
6	Өмчид гарсан өөрчлөлт			1,800,000,000.00		1,800,000,000.00
9	2017 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	60,388,037,164.58	1,503,964,488.14	19,975,469,815.51	-20,705,726,194.54	60,161,745,273.69
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				12,691.77	12,691.77
11	Залруулсан үлдэгдэл					
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				-2,294,010,082.05	-2,294,010,082.05
13	Бусад дэлгэрэнгүй орлого					
14	Өмчид гарсан өөрчлөлт			2,973,362,393.83		2,973,362,393.83
15	Зарласан ногдол ашиг					
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		15,131,701,951.04			15,131,701,951.04
17	2018 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	60,388,037,164.58	16,635,666,439.18	21,948,832,209.34	-22,999,723,584.82	75,972,812,228.28

(САГ-2019/107/СТА-ТӨХК)

4.4 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	16,039,106,473.31	14,777,212,384.47
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	10,271,314,218.13	10,106,934,353.20
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		154,875.00
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	17,286,325.00	32,744,194.52
1.1.4	Буцаан авсан албан татвар		
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	3,149,966,700.00	3,149,966,700.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	2,600,539,230.18	1,487,412,261.75
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	15,810,283,185.26	14,876,014,603.99
1.2.1	Ажиллагчдад төлсөн	3,178,089,214.06	3,308,150,839.53
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	794,547,859.39	915,439,547.70
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	4,602,315,729.58	3,659,329,409.58
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	377,820,970.91	410,746,873.88
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	1,405,536,151.93	2,513,831,494.30
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн	38,900.00	
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	960,588,011.21	992,435,694.58
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	12,875,586.00	27,719,009.29
1.2.9	Бусад мөнгөн зарлага	4,478,470,762.18	3,048,361,735.13
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	228,823,288.05	-98,802,219.52
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	18,275,986.10	50,291,836.94
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	950,000.00	18,325,000.00
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	17,325,986.10	31,966,836.94
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг		
2.1.8			
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	248,547,850.00	206,330,000.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	12,872,950.00	206,330,000.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		

(САГ-2019/107/СТА-ТӨХК)

“Алтай-Улиастайн эрчим хүчний систем” ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	235,674,900.00	
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
2.2.6			
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-230,271,863.90	-156,038,163.06
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)		
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.1.3	Төрөл бүрийн хандив		
3.1.4			
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)		
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
3.2.4	Төлсөн ногдол ашиг		
3.2.5			
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		
4	Валютын ханшийн зөрүү		
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-1,448,575.85	-254,840,382.58
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	708,213,334.63	706,764,758.78
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	706,764,758.78	451,924,376.20

Төрийн аудитын байгууллагаас хийсэн санхүү, гүйцэтгэл, нийцлийн аудитын хураангуй тайлангийн хавсралт

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2019-03-07	Аудитын нэр:	"Алтай-Улиастайн ЭХС" ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:	САГ-2019/107/СТА-ТӨХК
Шалгагдсан байгууллагын нэр:	Алтай-Улиастайн эрчим систем ТӨХК			Сая төгрөгөөр	

№	Аудитын зорилт, чиглэл	Тоо	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл			Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
					Нэр	Огноо	Дугаар	Албан тушаал	Овог нэр
А	1	2	3	4	5			9	10
1	Хөрөнгө	1	Техник, технологийн шинэчлэлтээс болж хоцрогдон, хэрэгцээгүй болсон сэлбэг хэрэгслийг үнэ хямдруулж борлуулах, актлах шийдвэр гаргаагүй байна.	20.9	Зөвлөмж өгсөн	3/7/2019	20	АУЭХС ТӨХК-ийн ерөнхий нягтлан бодогч, Богдын гол УЦС ХХК-ийн захирал	С. Ганзориг Ц. Улам-Оргих
2		1	Элэгдлийн норм, ашиглах хугацаа дууссан мөн осол, гэмтлийн улмаас цаашид ашиглах боломжгүй болсон 8.2 сая төгрөгийн үлдэгдэл өртөгтэй үндсэн хөрөнгийг актлуулах шийдвэр гаргуулаагүй байна.	8.2	Зөвлөмж өгсөн	3/7/2019	20	АУЭХС ТӨХК-ийн гүйцэтгэх захирал, Ерөнхий инженер, Дэд захирал, Ерөнхий нягтлан бодогч	А. Пүрэвсүрэн Б. Бээжин Д. Отгонбаяр С. Ганзориг

“Алтай-Улиастайн эрчим хүчний систем” ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

3		1	“Тосонцэнгэл УЦС” ХХК нь 4.9 сая төгрөгийн биет бус хөрөнгийг үндсэн хөрөнгөөр бүртгэж тайлагнасан байна.	4.9	Зөвлөмж өгсөн	3/7/2019	20	АУЭХС ТӨХК-ийн ерөнхий нягтлан бодогч, Тосонцэнгэл УЦС ХХК-ийн захирал	С. Ганзориг Н. Оюунцэцэг
4	Авлага	1	Олон жил дамжсан авлагыг барагдуулах ажил хийгээгүй байна	21.1	Зөвлөмж өгсөн	3/7/2019	20	Дэд захирал, Ерөнхий нягтлан бодогч, Дотоод хяналтын албаны дарга, Салбар болон охин компаниудын захирал, нягтлан бодогч нар	Д. Отгонбаяр С. Ганзориг Б. Наваанюндэн Г. Бадамхатан Ц. Улам-Оргих Н. Оюунцэцэг
5		1	“Тосонцэнгэл УЦС” ХХК нь 7.0 сая төгрөгийн урьдчилж төлсөн зардлыг авлагаар бүртгэж, тайлагнасан байна.	7.0	Зөвлөмж өгсөн	3/7/2019	20	АУЭХС ТӨХК-ийн ерөнхий нягтлан бодогч, Тосонцэнгэл УЦС ХХК-ийн захирал	С. Ганзориг Н. Оюунцэцэг
6	Татвар, шимтгэл	1	Зарим ажиллагсдад олгосон шагнал урамшууллыг нийгмийн даатгалын шимтгэлд хамруулаагүй байна.	8.3	Зөвлөмж өгсөн	3/7/2019	20	Дэд захирал, Ерөнхий нягтлан бодогч, Тооцооны нягтлан бодогч	Д. Отгонбаяр С. Ганзориг Г. Баянжаргал
7		1	Худалдаж авсан үндсэн хөрөнгийн Нэмэгдсэн өртгийн албан татварыг төсөвт төлөх татвараас хассан байна.	33.7	Зөвлөмж өгсөн	3/7/2019	20	Дэд захирал, Ерөнхий нягтлан бодогч, Борлуулалтын нягтлан бодогч	Д. Отгонбаяр С. Ганзориг Т. Дэлгэрмаа
Дүн				104.1					

